



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Ардчилсан намын улсын бүртгэлийн
мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, Б.Ундрах, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, М.Пүрэвсүрэн, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Ардчилсан намын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг шүүгч Г.Алтанчимэгийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намын дарга О.Цогтгэрэлийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/008 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтэд: “Улсын дээд шүүхийн 2000 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 07 дугаар тогтоолын Тогтоох хэсгийн 4-т “Ардчилсан намыг улсын бүртгэлийн дугаарт бүртгэхдээ МСДН-ыг улсын бүртгэлд анх бүртгэсэн дугаараар тооцугай. /1990-5-25/” гэсэн байна. Иймд Ардчилсан намын бүртгэлийн мэдээллийг 1990-5-25 болгон залруулж холбогдох баримт бичиг, дээд шүүхийн цахим хуудаст өөрчлөлт оруулна уу” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ардчилсан намын улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэв.

Учир нь, Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн шүүх хуралдааны 2000 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 07 дугаар тогтоолын Үндэслэх хэсэгт "... МСДН, МҮАН, МШАН, МАСНН, МоАН-ууд нь өөрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр нийлж “Ардчилсан нам”-ыг байгуулсан бөгөөд эдгээр намуудын эрх, үүргийг “Ардчилсан нам” хууль ёсоор залгамжлах болно, ... “Ардчилсан нам”-ыг улсын бүртгэлд бүртгэхдээ тухайн нийлсэн намуудаас хамгийн анх улсын бүртгэлд бүртгэгдсэн МСДН-ын бүртгэлийн огноогоор бүртгэх боломжтой гэж үзлээ” гэж дүгнэж, улмаар Тогтоох хэсгийн 4 дэх заалтаар “Ардчилсан нам”-ыг улсын бүртгэлийн дугаарт бүртгэхдээ МСДН-ыг улсын бүртгэлийн дугаараар тооцугай. /1990-5-25/ гэж шийдвэрлэжээ.

Монгол Улсын дээд шүүхийн Улс төрийн намын бүртгэлийн 2 дугаарт Ардчилсан намыг бүртгэсэн бөгөөд ийнхүү бүртгэхдээ намын мэдээлэлд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн огноог 2000-12-26 гэж тусгасан байна.

Тухайн мэдээлэл нь Монгол Улсын дээд шүүхийн 2000 оны 07 дугаар тогтоолд зааснаас өөр байх тул Ардчилсан намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн огноог өөрчилж зөвтгөн бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын дээд шүүхийн намын бүртгэлийн мэдээлэлд Ардчилсан намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн огноог “2000-12-26” гэснийг “1990-5-25” гэж өөрчилсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.АЛТАНЧИМЭГ